



МОНГОЛ УЛС
ХЭНГИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 12 сарын 21 өдөр

Дугаар А/655

Хэрлэн сум

Х.Мөнхцэцэгт тэтгэмж олгох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1.3 дахь заалт, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 02 дугаар тогтоол, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалаар батлагдсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 2 дугаар зүйлийн 2.1.4 дэх заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Хүүхэд хөгжил, хамгааллын жилийн үйл ажиллагааны төлөвлөгөөний хүрээнд дохионы хэлний сургагч багшаар бэлтгэгдэж буй Х.Мөнхцэцэгийн өргөдлийн дагуу түүнийг суралцаж байх хугацаанд 1,500,000 (нэг сая таван зуун мянга) төгрөгийн тэтгэмж олгосугай.

2.Тэтгэмж олгох зардлын хуваарийг хавсралтаар баталсугай.

3.Тэтгэмжид шаардагдах хөрөнгийг Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний “Хүүхэд хамгаалах жилийн төлөвлөгөө хэрэгжүүлэх зардал”-аас санхүүжүүлэхийг Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (С.Нямдаваа)-д, захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Нийгмийн бодлогын хэлтсийн дарга (Д.Өнөрцэцэг)-д тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ЧОГСОМЖАВ

Аймгийн Засаг даргын 2022 оны 12 дугаар сарын 21-ны дугаар захирамжийн хавсралт

Тэтгэмж олгох хуваарь

№	Зардлын нэр	Тоо	Нэг бүрийн үнэ	Дэмжлэг үзүүлэх хугацаа	Бүгд үнэ
1	Суралцах хугацааны тэтгэмж	3	500,000	1. 2022 оны 12 дугаар сар 2. 2023 оны 01 дүгээр сар 3. 2023 оны 02 дугаар сар	1,500,000
Нийт					1,500,000